



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ОЮУТНЫ ХОЛБОО, ОЮУТАН КОНГРЕСС

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Их Сургуулийн гудамж

МУИС-ийн оюутны I байр-01 тоот

Утас: 976-99065274, 94448977 75754400-1199

2017.01.23 № 01/52

Танай _____ -ны № _____ -т

Г

Шаардлага хүргүүлэх тухай

МУИС-ИЙН ЭЗХБЭЭ ЗАХИРАЛ Ч.НАРАНТУЯА
ТАНАА

Танд энэ өдрийн мэнд хүргэе!

Өнөө нийгмийн эдийн засгийн гүн хямрал болон олон хүчин зүйл нийт оюутнуудын сургалтын төлбөр төлөх чадварт ихээхэн хүндээр нөлөөлж байна. Иймд Монгол Улсын Их Сургуулийн захиргаа нь сургалтын төлбөрийн талаарх асуудалд уян хатан нөхцөлөөр хандаж энэхүү хүнд цаг үед нийт оюутнуудаа бодсон шийдвэр гаргаж өгөхийг нийт оюутны санал хүсэлтийн дагуу хүргүүлж байна. Үүнд:

1. Төлбөр төлөх нөхцөлд уян хатан байдлаар хандах (нэг улиралд төлбөрийг хоёр хувааж авах гэх мэт)
2. Суурь хураамж болон түүнтэй холбоотой асуудлуудад дэлгэрэнгүй тайлбар мэдээлэл өгөх (суурь хураамжийн зарцуулалт, тайлан, чөлөө авсан оюутнууд суурь хураамжийг төлдөг байдал)
3. Олон нийт, оюутнуудын дунд МУИС-ийг мөнгөн хуримтлалтай талаархи мэдээлэл тархаад байна. Энэ асуудалд үнэн зөв тайлбар мэдээлэл хийх.
4. Суурь хураамжийг авахдаа бидэнд таатай сургалтын орчин /анги танхимийн тохижилт, урсгал засвар, лаборатори тоног төхөөрөмж, номын сан, бие даах төвийн ном бүрдүүлэлт, чанартай боловсрол, мэдээлэл програм хангамжийн үйлчилгээ хөгжүүлэлт/ СиСи/, зэрэг үйлчилгээнүүдийг үзүүлэхээр авдаг ч энэ нь үнэн бодитоор хэрэгжсэн зүйлгүй хэвэндээ байсаар байна.

Иймд суурь хураамжийг энэ хаврын улиралаас эхлэн авахгүй байхыг нийт оюутнуудын санал хүсэлтийн дагуу шаардаж буй бөгөөд ажлын хоёр хоногт багтаан өгнө үү.

Хүндэтгэсэн;

ТЭРГҮҮН



Б.ХОСБААТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

14201 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж 1,
Утас/Факс: (976-11) 32-06-68

2017.01.27 № 4/257
танай 2017.01.23 -ны № 01/52 -т

МУИС-ИЙН ОЮУТНЫ ХОЛБОО,
ОЮУТАН КОНГРЕССТ

Танай ирүүлсэн 2017 оны 01/52 тоот шаардлагын дагуу холбогдох тайлбарыг хавсралтаар хариу хүргүүлж байна.

Хавсралт 5 хуудастай.


ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН
АСУУДАЛ ЭРХЭЛСЭН
ДЭД ЗАХИРАЛ

Ч.НАВАНТУЯА

УХД0072 9104399

20170122
My doc.Alban bichig A5 P-41

**Нийтлэг үйлчилгээний суурь төлбөр, түүний зарцуулалт,
мөнгөний үлдэгдлийн тухай тайлбар**



1. Их сургуульд оюутны хичээлээ сонгох боломж бүрдээгүй байх үед бүх оюутныг нэгэн ижил хичээл судлуулахаар сургууль нь урьдчилан оноож, түүнд харгалзуулан төлбөрийн хэмжээг бүхлээр нь нэгэн ижил хэмжээгээр тогтоож улирал харгалзахгүй бөөнөөр нь авдаг байсан. Их сургуулиуд кредит буюу багц цагт суурилсан сургалтын зохион байгуулалтад шилжсэнтэй холбоотойгоор санхүүгийн болон сургалтын систем, холбогдох эрх зүй нь өөрчлөгдсөн. Сургуулийн үйл ажиллагаа нь хичээлийн 2 улиралтай бөгөөд суралцаж байгаа оюутан өөрийн боловсрол эзэмших үйл явцын эзэн нь байж, аль хичээлийг хэдийд сонгон үзэхээ шийддэг зарчимд шилжснээр оюутан бүр өөрийн сонирхол, боломжид тулгуурлан сонголт хийж байгаа тохиолдолд төлбөр тооцооны системийг ч үүнд нийцүүлсэн. Оюутан бүр өөрийн боломжид тулгуурлан хэдэн кредитийн хичээлийг тухайн семестрт сонгон судалж байна, түүндээ таарсан төлбөрийг улирал, улиралдаа төлөх боломжтой болсон. Захирлын 2015 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/203 тоот тушаалаар батлагдсан "МУИС-ийн сургалтын журам"-д хичээлийг сонгон бүртгүүлснээс хойш 24 цагийн дотор төлбөрөө төлөн баталгаажуулна. Баталгаажуулаагүй хичээлийг цуцална гэж заасан нь сургуулийн болон сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах зорилготой. Иймээс МУИС-ийн холбогдох журмын дагуу нэг улирлын төлбөрийг 2 хуваан төлүүлэх боломжгүй бөгөөд энэ нь сургуулийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулах эрсдэлтэй. Түүнчлэн нийгэм, эдийн засгийн хямралтай уялдуулан төрөөс болон сургуулийн зүгээс оюутны сургалтын төлбөрийн талаар олон талын дэмжлэг үзүүлж байна. Энэ нь Сургалтын төрийн сангийн зээл, оюутны хөгжлийн зээл, үндэсний тэтгэлэг, МУИС-ийн тэтгэлэг болон бусад гадаад болон дотоод байгууллагын тэтгэлэг зэрэг нээлттэй олон боломж бий болсон.
2. МУИС-ийн сургалтын төлбөрийг тогтоох асуудал захиргааны эрх мэдлийн бус, Удирдах зөвлөлийн шийдвэрээр тогтоогддог, түүнд оюутны төлөөлөл өргөн бүрэлдэхүүнээр оролцож, хамтын шийдвэр гаргаж ирсэн. 2011 онд МУИС-ийн Удирдах зөвлөл сургалтын төлбөрийн хэмжээг оюутны сонгох хичээлийн багц цагийн төлбөр (tuition) болон нийтлэг авах үйлчилгээний суурь төлбөр (fees)-ийн нийлбэр байхаар тогтоосон нь олон улсын жишигт байдаг практик юм. Сургалтын төлбөрийг ийнхүү тогтоохдоо Монгол улсын Гэгээрлийн сайдын 1999 оны 107 дугаар тушаалыг үндэслэн боловсруулсан болно.

Монгол улсын Гэгээрлийн сайдын 1999 оны 107 дугаар тушаалын хавсралтаар "Их сургууль, коллежийн төсөв зохиох, сургалтын төлбөрийг тодорхойлох үлгэрчилсэн аргачлал"-ыг баталсан. Энэ аргачлалаар сургалттай холбоотой шууд зардлууд, захиргаа аж ахуйн зардлын ангилалыг тогтоож, санхүүжүүлэх эх үүсвэрийг баталсан. Энэхүү аргачлалаар зардлын аль аль нь сургалтын төлбөрт тусах ёстой бөгөөд үүнийг бусад их дээд, сургуулиуд багц цагийн төлбөртөө тусган нэг дор авдаг. Харин МУИС энэ

зардлаа дээрх 2 хэсэгт хувааж сургалтын төлбөртөө тусгадаг болно. МУИС-ийн “Сургалтын журам”-ын 4.13.1-д сургалтын төлбөр нь багц цагийн төлбөр, суурь үйлчилгээний төлбөрийн нийлбэрээр тодорхойлогдоно гэж заасан.

МУИС-ийн төсвийн зарлагыг сургалттай холбоотой зардлууд, захиргаа, аж ахуйн, ашиглалтын зардал, оюутны үйлчилгээний зардал, сургууль хөгжүүлэх зардал буюу хөрөнгө оруулалтын зардал, судалгаа, эрдэм шинжилгээний зардал гэсэн бүрдэл хэсэгтэй. Хүснэгт1-д харуулав. Үүнээс байрны ашиглалтын зардлыг (харуул хамгаалалтаас бусад) улсын төсвөөс хариуцдаг. Оюутан хэдэн хичээл сонгохоос хамааралгүй гардаг зардал буюу захиргаа, аж ахуй, шуудан холбоо, сургалтын алба, мэдээллийн технологи, оюутны үйлчилгээ, номын сан, цэвэрлэгээ, урсгал засвар, ажилтан, ажилчдын цалин хөлс зэрэг нь нийтлэг үйлчилгээний зардал бөгөөд үүний тодорхой хэсгийг суурь төлбөрөөс санхүүжүүлж байна.

Харин хичээл сургалттай шууд холбогдох багшийн цалин, тэднийг хөгжүүлэх зардал, хичээл практик, сургалтын лаборатори, кабинетын багаж хэрэгсэл, түүхий эд, урвалж бодис, ашиглалтын зардлыг багц цагийн төлбөрт шингээсэн байгаа юм. Үүний дүнд оюутан хүн сонгосон хичээлийн тооноосоо хамааран нийтлэг үйлчилгээний зардлыг дахин дахин давхардуулан төлөхөөс хамгаалсан зарчим юм. Олон улсын их сургуулиудад баримталдаг сургалт, нийтлэг үйлчилгээний төлбөрийн задаргааны энэ зарчим бол 1990-ээд оноос хойш бидний хэрэгжүүлэхийг зорьж буй кредитийн системд шилжих үйл явцын үндсэн зарчим гэдгийг боловсролын салбарынхан ч ойлгож, нэвтрүүлэх хэрэгтэй.

Хүснэгт 1. МУИС-ийн зардлын гол бүлгүүд санхүүжүүлэх эх үүсвэр

Зардлын гол бүлэг	Санхүүжүүлэх эх үүсвэр
<p>Сургалттай холбоотой зардал:</p> <ul style="list-style-type: none"> - Багш, тэнхимийн туслах ажилтан цалин хөлс, НДШ - Хичээл практик - Мэргэжлийн олимпиад - Интернет - Хэвлэлийн зардал - Багшийн мэргэжил дээшлүүлэх 	Багц цагийн төлбөрөөс
<p>Захиргаа аж ахуйн зардал:</p> <ul style="list-style-type: none"> - Удирдах, мэргэжлийн болон техник үйлчилгээний ажилтны цалин хөлс, НДШ - Бичиг хэргийн зардал - Шуудан холбоо, интернет - Мэдээллийн технологи - Номын сангийн үйлчилгээ - Тээвэр шатахуун - Албан томилолт - Гадаад арга хэмжээ - Төвлөрсөн арга хэмжээ - Төлбөр хураамж /гишүүнчлэл ... г.м/ 	Үйл ажиллагааны бус орлого, нийтлэг үйлчилгээний суурь төлбөрөөс

- Хог хаягдал, цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал, халдваргүйжүүлэлт	
Оюутны үйлчилгээний зардал: - Оюутны эрдэм шинжилгээ - Оюутны спорт, урлаг соёл, олон нийтийн арга хэмжээ - Оюутны тэтгэлэг - Оюутны хөдөлмөр эрхлэлт	Оюутны үйлчилгээний хураамж, сургалтын төлбөрөөс (багц цагийн төлбөр+нийтлэг үйлчилгээний суурь төлбөр) УХД0072 9104399
Ашигалтын зардал: - Харуул, хамгаалалт	Нийтлэг үйлчилгээний суурь төлбөрөөс
Эрдэм шинжилгээ, инновацийн зардал: - Сургуулийн хэтийн хөгжилтэй холбогдсон судалгаа, шинжилгээний зардал - Эрдэм шинжилгээний ажлын шууд зардал - Эрдэм шинжилгээний ажлын шууд бус зардал	Эрдэм шинжилгээ, төсөл хөтөлбөр, тодорхой хувийг сургалтын төлбөрөөс
Сургууль хөгжүүлэх хөтөлбөрийн зардал буюу хөрөнгө оруулалтын зардал: - Их засвар - Урсгал засвар - Шинээр үндсэн хөрөнгө бий болгох, худалдан авах - Хөрөнгө оруулалт	Сургалтын төлбөрөөс (багц цагийн төлбөр+нийтлэг үйлчилгээний суурь төлбөр)
Хөрөнгө оруулалтын зардал: - Томоохон хэмжээний их засвар - Сургалт, судалгааны лаборатори - Барилгын хөрөнгө оруулалт	Улсын төсөв болон бусад хөнгөлөлттэй зээл тусламж, хандив
Ашигалтын зардал: - Гэрэл цахилгаан - Дулаан, халаалт, түлш - Цэвэр, бохир ус - Оюутны замын зардлын хөнгөлөлт	Улсын төсвөөс


МУИС суурь төлбөрийг ялган тогтоосноор:

- Нийтлэг үйлчилгээний төлбөрийг давхардуулан авахыг зогсоох;
- Багц цаг олноор сонгож байгаа хүүхдүүдэд санхүүгийн илүү өндөр ачаалал ирэх учир үүнийг зохицуулах;
- Оюутнууд богино хугацаанд кредитээ цуглуулаад төгсөх хөшүүрэг бүрдүүлэх ач холбогдолтой.

МУИС-ийн оюутан чөлөө авч байгаа тохиолдолд үйлчилгээний суурь төлбөр төлөх талаар “Сургалтын журам”-ын 4.11.1.4, 4.11.1.5, 4.5.23-д заасны дагуу зохицуулахаар журамласан. Энэ нь их сургуулийн оюутан байх статусыг хадгалах, оюутны үргэлжлүүлэн суралцах боломжийг бүрдүүлэх, чөлөөтэй хугацаандаа сургуулиасаа үйлчилгээ авах (интернэт, номын сангийн үйлчилгээ, бүх төрлийн тодорхойлолт зэрэг) боломжийг бүрдүүлж байгаа.

3. МУИС-ийн үндсэн үйл ажиллагаа нь хичээлийн жилээр явагддагтай холбоотой сургалтын төлбөрийн орлого нь жилдээ 2 удаа буюу хавар ба

намрын семестрийн эхэнд орж ирдэг. Намрын семестрийн эхэнд буюу 8-р ба 9-р сард орж ирсэн орлогыг дараагийн санхүүгийн жил дамнуулан оны эхний 2.5 сард гарах зардлыг санхүүжүүлэхэд ашигладаг болно. Үүний дагуу санхүүгийн жилийн эцэст дараа оны эхний саруудад хэрэглэх орлогыг шилжүүлдэг бөгөөд энэ нь дараа оны төсөвт мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл хэлбэрээр тусгагддаг болно.



Энэхүү мөнгөн дүн нь МУИС төсвийн жилийн эцэст их хэмжээний мөнгөн хуримтлалтай мэт харагдуулах боломжтой. Гэвч энэ сургуулийн үйл ажиллагааны мөчлөг нь санхүүгийн жилийн мөчлөгөөс ялгаатай байгаагаас шалтгаалж буй онцлог юм.

Түүнчлэн МУИС-ийн шинэ номын сангийн барилгын хуримтлалд 2000-2015 он хүртэл 7.7 тэрбум төгрөг хуримтлуулж ирсэн. Энэхүү хуримтлал нь МУИС-ийн Хөгжлийн сангийн хуримтлал, улсын төсвийн санхүүжилт, хандивын хөрөнгө, бүтэн орон тооны төлөвлөлтөөс үүссэн цалингийн хэмнэлт (урт болон богино хугацаагаар түр чөлөөтэй үндсэн багшийн оронд цагийн багшаар хичээл орох, багшийн шилжих хөдөлгөөн) болон эрх зүйн орчны шинэчлэлээр үүссэн төсвийн хэмнэлт зэрэг олон эх үүсвэрээс бүрдсэн байгаа.

2012 оноос эхлэн санхүүгийн жилээр үйл ажиллагааны төсөв хийх болсонтой холбогдон эдгээр сангийн хуримтлалаас гадна урьдчилж орсон орлого, бие даасан нэгжүүдийн мөнгөний үлдэгдэл, эрдэм шинжилгээ, төслийн орлого нь мөн оны эцсийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тусгагдаж байгаа болно. Тухайлбал, МУИС-ийн харьяанд Монгол-Япон төв, Цөмийн судалгааны төв, хэвлэх үйлдвэр, эрдэм шинжилгээний олон тооны төсөл хөтөлбөр, Монгол судлалын хүрээлэн, МУИС пресс, Бизнес төв, БЭЛАС, МСҮТ гэх мэт бие даасан олон байгууллагууд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд эдгээрийн төсөв ба санхүүгийн тайлан нь МУИС-ийн нэгдсэн төсөв ба тайланд тусгагддаг. Эдгээр нэгжүүдийн үйл ажиллагаа нь оюутны сургалтын төлбөрөөс санхүүждэггүй болно.


2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 21.7 тэрбум төгрөг байна. Үүний 8.9 тэрбум төгрөг нь сургалтын бус үйл ажиллагаа явуулдаг нэгжүүдийн мөнгөний үлдэгдэл, номын сангийн барилгын үлдэгдэл санхүүжилт 4.7 тэрбум төгрөг, урьдчилж орсон санхүүжилт 8.1 тэрбум төгрөг нь байна.

4. 2016 санхүүгийн тайлангаар нийт 28.2 тэрбум төгрөгийн багц цагийн төлбөр, 3.3 тэрбум төгрөгийн суурь үйлчилгээний төлбөрийн орлого орсон байна Үүнээс сургалтын орчныг сайжруулахтай холбоотой дараах хөрөнгө оуулалтыг хийжээ.

- 2016 онд номын сангийн барилгын санхүүжилтэд 7.8 тэрбум төгрөг;
- Хичээлийн байруудын их ба урсгал засварт 1.4 тэрбум төгрөг;
- Сургалтын тоног төхөөрөмж тавилга, эд хогшилд 1.3 тэрбум төгрөг;
- Номын фондын шинэчлэлд 232.2 сая төгрөг;
- Мэдээллийн системийн хөгжүүлэлтэд 50.0 сая төгрөг нийт 10.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна.

Түүнчлэн улсын төсвөөс дараах санхүүжилтийг хийсэн байна. Үүнд:

2013 онд	698.6 сая төгрөг	
2014 онд	639.0 сая төгрөг	
2015 онд	1329.1 сая төгрөгийн сургалт, судалгааны лаборатори, лабораторийн тоноглол эд хогшил;	
2013 онд	186.5 сая төгрөг	
2014 онд	1939.2 сая төгрөг	
2016 онд	646.8 сая төгрөгийн урсгал ба их засвар, хөрөнгө оруулалтын санхүүжилт хийгдсэн байна.	



Нийтлэг авах үйлчилгээний суурь төлбөрийн орлого нь захиргаа, төвлөрсөн үйлчилгээний зардлын 40.3 хувийг эзэлж байна.

Санхүү эдийн засгийн алба